

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн хорин долоо дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2024/026/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70359826 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70359832 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
“Төгс Нотолгоо аудит” ХХК-ийн Ахлах аудитор Д.Оюунжаргал
Утас: 99460422 Цахим хаяг oyunjargaldankhar99@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Төлбөрийн акт.....	
5.2 Албан шаардлага.....	
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.21 № 44
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ХОРИН ДОЛОО
ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.БАТЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн хорин долоо дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн хорин долоо дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд хичээлийн байрны хүчин чадлыг 159 хүүхдээр тооцсон боловч 92 хүүхэд суралцаж, улсын төсвөөс гүйцэтгэлээр санхүүжиж байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн хорин долоо дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитаар АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

D:\my doc \alban bichig\2025-A4.doc

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>119,104,335.11</u>	<u>120,301,006.36</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	104,920,347.79	78,309,503.04
312	Банканд байгаа бэлэн мөнгө	104,920,347.79	78,309,503.04
3121	Төгрөг	104,920,347.79	78,309,503.04
31211	Төрийн сангийн харилцах	104,920,347.79	78,309,503.04
35	БАРАА МАТЕРИАЛ	14,183,987.32	41,991,503.32
351	Түүхий эд материал	13,242,697.32	40,816,063.32
35110	Тусгай зориулалттай материал	13,242,697.32	40,816,063.32
354	Хангамжийн материал	941,290.00	1,175,440.00
35460	Хүнсний материал	941,290.00	1,175,440.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,103,013,543.50</u>	<u>2,061,720,047.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,103,013,543.50	2,061,720,047.15
392	Биет хөрөнгө	1,889,373,543.70	1,848,080,047.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,626,658,000.00	1,634,327,503.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,243,862.28	-57,672,488.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	130,000,000.00	130,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9,749,999.97	-22,749,999.93
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	117,392,821.00	168,151,811.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,207,103.19	-45,717,720.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,581,878.00	64,482,488.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,058,189.86	-22,741,545.28
393	Биет бус хөрөнгө	213,639,999.80	213,639,999.80
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.20	-400,000.20
39303	Бусад биет бус хөрөнгө	213,640,000.00	213,640,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,222,117,878.61</u>	<u>2,182,021,053.51</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>-</u>	<u>-</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,222,117,878.61</u>	<u>2,182,021,053.51</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,222,117,878.61	2,182,021,053.51
512	Хуримтлагдсан үр дүн	2,222,117,878.61	2,182,021,053.51
51210	Өмнөх үеийн үр дүн	2,222,117,878.61	2,222,117,878.61
51220	Тайлант үеийн үр дүн	-	-40,096,825.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,222,117,878.61</u>	<u>2,182,021,053.51</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	724,185,600.00	1,013,004,544.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,542,000.00	107,826,244.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,542,000.00	107,826,244.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,542,000.00	40,781,275.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,542,000.00	40,781,275.00
120006	Газрын тосны орлого		52,149,603.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө		14,895,366.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	718,643,600.00	905,178,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	673,502,000.00	841,836,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	673,502,000.00	841,836,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,141,600.00	63,341,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,141,600.00	63,341,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	667,487,679.90	1,051,394,650.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	667,487,679.90	1,051,394,650.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	644,743,564.06	1,035,007,610.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	457,082,276.00	718,523,306.05
210101	Үндсэн цалин	345,795,456.00	453,023,436.05
210102	Нэмэгдэл	96,403,978.00	240,715,256.00
210104	Урамшуулал	14,882,842.00	24,784,614.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,432,877.78	88,951,820.70
210201	Тэтгэврийн даатгал	39,285,560.79	60,818,064.49
210202	Тэтгэмжийн даатгал	4,619,973.43	7,035,743.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,647,618.72	3,657,994.80
210204	Ажилгүйдлийн даатгал	807,199.96	3,337,653.22
210205	Эрүүл мэндийн даатгал	8,072,524.88	14,102,364.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,597,484.16	20,954,559.74
210301	Гэрэл, цахилгаан	5,812,060.43	7,518,539.17
210302	Түлш, халаалт	9,932,199.28	8,701,263.87
210303	Цэвэр, бохир ус	4,853,224.45	4,734,756.70
2104	Хангамж, бараа материалын зардал	3,108,100.00	5,554,800.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,004,600.00	5,554,800.00
2105	Нормативт зардал	54,999,405.00	69,516,950.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс	54,999,405.00	69,516,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,800,000.00	13,360,000.00
210604	Урсгал засвар	1,800,000.00	13,360,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	856,500.00	945,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	856,500.00	945,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,866,921.12	117,201,173.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,518,743.00	17,434,293.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,584,900.00	8,030,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,763,278.12	91,736,380.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,744,115.84	16,387,040.26

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	16,387,040.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	16,387,040.26
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,744,115.84	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,744,115.84	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	56,697,920.10	(38,390,106.34)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,706,718.76
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1,706,718.76
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,706,718.76)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	56,697,920.10	(40,096,825.10)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	724,185,600.00	945,959,575.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,542,000.00	40,781,275.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,542,000.00	40,781,275.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,542,000.00	40,781,275.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,542,000.00	40,781,275.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	718,643,600.00	905,178,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	673,502,000.00	841,836,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	673,502,000.00	841,836,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,141,600.00	63,341,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,141,600.00	63,341,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	633,452,591.78	972,570,419.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,452,591.78	972,570,419.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	610,708,475.94	956,183,379.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	457,082,276.00	718,523,306.05
210101	Үндсэн цалин	345,795,456.00	453,023,436.05
210102	Нэмэгдэл	96,403,978.00	240,715,256.00
210104	Урамшуулал	14,882,842.00	24,784,614.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,432,877.78	88,951,820.70
210201	Тэтгэврийн даатгал	39,285,560.79	60,818,064.49
210202	Тэтгэмжийн даатгал	4,619,973.43	7,035,743.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,647,618.72	3,657,994.80
210204	Ажилгүйдлийн даатгал	807,199.96	3,337,653.22
210205	Эрүүл мэндийн даатгал	8,072,524.88	14,102,364.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,597,484.16	20,954,559.74
210301	Гэрэл, цахилгаан	5,812,060.43	7,518,539.17
210302	Түлш, халаалт	9,932,199.28	8,701,263.87
210303	Цэвэр, бохир ус	4,853,224.45	4,734,756.70
2105	Нормативт зардал	55,940,695.00	69,751,100.00
210502	Хоол, хүнс	55,940,695.00	69,751,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,800,000.00	26,000,000.00
210604	Урсгал засвар	1,800,000.00	26,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	856,500.00	2,725,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	856,500.00	2,725,500.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,998,643.00	29,277,093.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,413,743.00	21,246,593.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,584,900.00	8,030,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,744,115.84	16,387,040.26
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,744,115.84	16,387,040.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,744,115.84	16,387,040.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	90,733,008.22	(26,610,844.75)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	90,733,008.22	(26,610,844.75)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		104,920,347.79
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	104,920,347.79	78,309,503.04

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	1,916,784,600.0	1,916,784,600.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,222,117,878.61	2,222,117,878.61
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	2,222,117,878.61	2,222,117,878.61
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,222,117,878.61	2,222,117,878.61
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(40,096,825.10)	(40,096,825.10)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,182,021,053.51	2,182,021,053.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,070,606,200.00	956,183,379.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,070,606,200.00	956,183,379.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,070,606,200.00	956,183,379.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	801,005,400.00	718,523,306.05
210101	Үндсэн цалин	524,106,000.00	453,023,436.05
210102	Нэмэгдэл	263,707,000.00	240,715,256.00
210104	Урамшуулал	13,192,400.00	24,784,614.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,882,100.00	88,951,820.70
210201	Тэтгэврийн даатгал	63,841,000.00	60,818,064.49
210202	Тэтгэмжийн даатгал	7,509,500.00	7,035,743.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,755,200.00	3,657,994.80
210204	Ажилгүйдлийн даатгал	3,755,200.00	3,337,653.22
210205	Эрүүл мэндийн даатгал	15,021,200.00	14,102,364.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,341,600.00	20,954,559.74
210301	Гэрэл, цахилгаан	12,817,700.00	7,518,539.17

210302	Түлш, халаалт	15,636,100.00	8,701,263.87
210303	Цэвэр, бохир ус	8,887,800.00	4,734,756.70
2105	Нормативт зардал	75,232,800.00	69,751,100.00
210502	Хоол, хүнс	75,232,800.00	69,751,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,000,000.00	26,000,000.00
210604	Урсгал засвар	26,000,000.00	26,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,726,600.00	2,725,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,726,600.00	2,725,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,417,700.00	29,277,093.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,387,200.00	21,246,593.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,030,500.00	8,030,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,070,606,200.00	945,959,575.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	966,483,325.00	841,836,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	966,483,325.00	841,836,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	63,341,600.00	63,341,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	63,341,600.00	63,341,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	40,781,275.00	40,781,275.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,781,275.00	40,781,275.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		104,920,347.79
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		78,309,503.04

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон аймгийн хүүхдийн хорин долоо дугаар цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага бөгөөд БШУС-ын багцад хамаардаг, Боловсролын ерөнхий газрын газрын харьяа байгууллага юм.

Тус цэцэрлэг нь сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хувьд ердийн болон тусгай гэсэн хэв шинжтэй. Ердийн-4, тусгай-2 бүлэгтэйгээр сургалт, үйл ажиллагаагаа явуулдаг.

Орхон аймгийн хүүхдийн хорин долоо дугаар цэцэрлэг нь 2023-2024 оны хичээлийн жилд “Үнэлгээний үр дүнд суурилан, цэцэрлэгийн менежментийг хамтын оролцоотой сайжруулж, сургалтын чанарт ахиц гаргана” гэсэн зорилгын хүрээнд дараах 8 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

- Боловсролын багц хууль болон дагалдах эрх зүйн баримт бичгийг эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийтэд таниулах, тэдний оролцоотой хэрэгжүүлэн хүүхэд бүрийн хөгжлийн эцэг эхтэй хамтран дэмжих
- Боловсролын үйлчилгээний чанарын ялгааг бууруулан, хүүхэд бүрийг тэгш хамруулан сургаж тэдний онцлог сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэгийг үзүүлэн, 5 настай хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулан сургуульд элсэн суралцах бэлтгэлийг хангах
- Хүүхэд бүрийн хөгжлийн хоцрогдлыг илрүүлж, тэдний онцлог ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан нөхөх, арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж, хөгжлийн ахиц гаргах

- Сургалтын шинэлэг арга зүй технологийг туршин хэрэгжүүлж, мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг сайжруулан, багшийн заах арга зүйд ахиц гаргах
- Цэцэрлэгийн орчин дах аливаа хэлбэрийн эрсдэлийг бууруулах, хянах, үнэлэх зэрэг үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулах, эцэг эх, асран хамгаалагчдад энэ талын мэдлэгийг нэмэгдүүлэх
- Онцгой байдлын үед хүүхэд өөрийгөө хамгаалах, мэдлэг ур чадварыг эзэмшихэд багш, эцэг эхтэй хамтран дэмжих
- Цэцэрлэгийн номын сангийн фондыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг олон хэлбэрээр зохион байгуулан нээлттэй байдлыг хангах
- Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн газрын үйл ажиллагааг сайжруулан эцэг эхэд хоол тэжээлийн боловсрол олгох

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган нийт 50 ажил төлөвлөж, гүйцэтгэлийн биелэлт 98 хувьтай байна

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь тайланд онд үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажилласан байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019 оны 5, 6, 7,9 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2022 оны 490 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол
- Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол
- Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал
- Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дүгээр тушаал
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 дугаар тушаал
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал
- Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал 2024 оны А/85, А/34 дүгээр тушаал
- Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал 2022 оны А/238, А/340 дүгээр тушаал
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаал
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаал

Тайлант онд Боловсролын ерөнхий хуульд 3, Төсвийн тухай хуульд 8, Төрийн хэмнэлтийн тухай хуульд 3, Хөдөлмөрийн тухай хуульд 2, Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 3, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагаа нь үндсэн үйл ажиллагаанд чиглэж, төсөв санхүү, нягтлан бодох бүртгэл болон шилэн данс, төрийн хэмнэлтийн хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийсэн байх тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Дотоод аудиторын чиг үүргийг хэрэгжүүлэх орон тоо байдаггүй тул аудитад ашиглах шаардлага үүсээгүй болно

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн хорин долоо дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус цэцэрлэг нь 2020 онд Орхон аймгийн Засаг даргын захирамжаар баталсан "Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг ашиглаж байгаа боловч цаашид чанар, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжиж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад нэгтгэгддэг, Боловсролын ерөнхий газрын харьяа байгууллага тул "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэн батлуулж мөрдөх шаардлагатай байна

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон аймгийн хорин долоо дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын баталсан төсөвт байгууллагад мөрдөх заавар, журмын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,096.8 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	104,920.30	78,309.50	- 26,610.8
Авлага	-	-	-
Бараа материал	14,183.90	41,991.50	27,807.60
Үндсэн хөрөнгө	2,103,013.50	2,061,720.00	- 41,293.5

Нийт хөрөнгө	2,222,117,8	2,182,021.00	- 40,096.8
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,222,117,8	2,182,021.00	- 40,096.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,222,117,8	2,182,021.00	- 40,096.8

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгө өмнөх оноос 40,096.8 мянган төгрөгөөр буурахад тайлант оны үр дүн нөлөөлжээ.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 26,610.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд урамшуулалт цалинг батлагдсан төсвөөс хэтрүүлэн олгосонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41,991.5 мянган төгрөг болж 27,807.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 19,608.7 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал худалдан авсан, 6,610.6 мянган төгрөгийн материал нийлүүлэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,061,720.0 мянган төгрөг болж 41,293.5 мянган төгрөгөөр буурсан нь 2023 онд ашиглалтад орсон цэцэрлэгийн барилгын ашиглах хугацааны элэгдлийг тайлант онд байгуулж зардалд бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,182,021.0 мянган төгрөг болж 40,096.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд алдагдалтай ажилласнаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 654,673.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 63,341.6 мянган төгрөг, нийт зарлагыг 718,015.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 21,273.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж. 739,288.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 331,317.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 966,483.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 63,341.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 40,781.3 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 841,836.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 63,341.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлогоор 40781.3 мянган төгрөгийг бүртгэсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 956,183.4 мянган төгрөг буюу 89.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 82,482.1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4,930.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 16,387.0 мянган төгрөг, нормативт зардлыг 5,481.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 5,140.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
УЛСЫН ТӨСӨВ					
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1,007,264.6	909,228.8	- 78,309.5	-91.1%
1.1	80233 Хүүхэд хамгаалал	1,090.4	0.0	- 1,090.4	0%
1.2	81549 Ахмадын сан	89.6	89.6	0.0	100%
1.3	81605 Эрүүл мэндийг дэмжих	2,210.6	1,665.0	- 545.6	75.3%
1.4	81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	75,232.8	69,751.1	- 5,481.7	92.7%
1.5	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,119.8	3,119.8	0.0	100%
1.6	81823 Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,912.7	0.0	- 1,912.7	0%
1.7	81834 Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	853,085.1	785,534.7	- 67,550.5	91%
1.8	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	8,010.8	6,282.2	- 1,728.6	78.4%
1.9	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	5,011.5	5,011.5	0.0	100%
1.10	83602 ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	57,501.3	37,774.9	-19,726.4	65.6%
ОРОН НУТГИЙН ТӨСӨВ					
2	71801 Сургуулийн өмнөх боловсрол	63,341.6	46,954.6	16,387.0	74.1%
2.1	80112 Нийтлэг үйлчилгээ	63,341.6	46,954.6	16,387.0	74,1%
	Нийт гүйцэтгэл	1,070,606.2	956,183.4	94,696.4	89.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Боловсролын байгууллага нь гүйцэтгэлээр санхүүждэг болсонтой холбоотойгоор нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд гадаад, дотоодын эх үүсвэрээс санхүүжих төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд хүүхдийн хоолны зардалд батлагдсан төсвөөс 75,232.8 мянган төгрөгийн 5 багц хүнсний бүтээгдэхүүн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн хуваарь ирсний дараа баталсан байна.

Тендерийн үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг 5 багц хүүхдийн хоол, бусад материал худалдан авахаар боловсруулан баталжээ.

Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу цахимаар зохион байгуулж, 3 багцын нийлүүлэгчийг шалгаруулан, 2 багцыг өмнөх оны бэлтгэн нийлүүлэгчийн гэрээг сунган ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхон аймгийн хорин долоо дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Төгс нотолгоо аудит” ХХК-ийн ахлах аудитор Г.Цэцэгмаа, Д.Оюунжаргал, аудитын туслах А.Лхагважав нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн хорин долоо дугаар цэцэрлэгийн 2024 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 1,070,606.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 21,412.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу тухайн байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихын зэрэгцээ гарч болох эрсдэлийг төлөвлөгөө, гүйцэтгэлд тусгасан бөгөөд байж болох хувилбарыг түүвэрлэн авч горим сорил хэрэгжүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 159 талбарын мэдээллээс 159 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцлийн асуудлыг үнэлэх асуудал үүсээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Орхон аймгийн хорин долоо дугаар цэцэрлэгийн 2024 оны 3-р улирлын санхүүгийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл хөтөлж, шалгагдагч байгууллагад танилцуулсан.

Завсрын аудитаар нийт 729,3 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийн биелэлт бүрэн хангагдсан тул тайлант оны буруу илэрхийлэлд оруулан тооцох зөрчил байхгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Орхон аймгийн хорин долоо дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор н.Наранчимэг гүйцэтгэсэн бөгөөд аудитаар 24,171.5 мянган төгрөгийн зөрчил 2 зөвлөмж авсан байна. Зөвлөмжийн биелэлтийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 06 дугаар сарын 10-ний өдөр 41 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	21,412.1	2	21,412.1	100.0
Нийт дүн	2	21,412.1	2	21,412.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулсан алдаа¹ байхгүй.

Аудитаар нийт 6,941.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,193.6 мянга төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,747.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт:

Тайлант онд 1 албан хаагчийн цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулан 318.8 мянган төгрөг илүү олгосон, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад заагаагүй шинжилгээнд албан хаагчдыг хамруулж, 180.0 мянган төгрөгийн зардлыг үр ашиггүй зарцуулсан, эрхлэгчид дээд газрын эрх зүйн зөрчилтэй тушаалыг үндэслэн 694.8 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон зөрчлүүдэд 3 төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага:

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн нийт 1,544.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлснийх нь төлөө эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг үндэслэж, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 3,769.5 төгрөгийн балансын урамшууллыг цалингийн зардлаас олгосон, байгууллагын хөрөнгөөр 14 багшид 434.0 мянган төгрөгөөр цамц худалдан авч өгсөн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ээлжийн амралтын нөхөн олговор авсан 1 ажилтанд цалин давхардуулан олгосон	1	318.8	1	318.8								
Байгууллагын 14 ажилтанд "Поло" хувцас худалдан авч өгсөн байна	1	434,0			1	434.0						
Журамд заагдаагүй албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулан төсвөөс 480.0 мянган төгрөгийг зарцуулсан	1	180.0	1	180.0								
Эрхлэгчид аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсролын газрын даргын 2024 оны 12 сарын 18-ны өдрийн А/63 дугаар тушаалыг үндэслэн 694.8 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон	1	694.8	1	694,8								
Цэцэрлэгийн эрхлэгч аймгийн Засаг даргын 2024 оны А/717 тоот захирамжаар 1 сарын үндсэн цалинтай	1	1,544.0			1	1,544.0						

тэнцэх шагнал, урамшуулал 1,544.0 мянган төгрөгийг байгууллагын цалингийн зардлаас тооцон олгосон байна.												
Төсөв захирагчид салбарын нэгдсэн үнэлгээгээр сургалт үйл ажиллагааны чанар, үр дүнгээр улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй үнэлэгдсэн гэх үндэслэлээр аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсролын газрын даргын 2024 оны 12 сарын 18-ны өдрийн А/63 тоот тушаалаар сарын үндсэн цалингийн 30 хувиар тооцож цалингийн зардлаас олгосон байна.	1	3,769.5			1	3,769.5						
Дүн	6	6,941.1	3	1,193.6	3	5,747.5						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл талбарын мэдээллээс 2 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байна.	-	-							
Дүн	-	-							